

# Манмин Мэдээ

Номер 24 2012 оны Долдугаар сарын 1

## “Ариун Сүнсний тэсрэлт мэт эрх мэдэлт хүчээр баяр ба сэтгэл хөдлөлөөр дүүрэн байлаа.”

### И Сү жин пасторыг урьсан 2012 оны Перу Номлогчдын семинар, Эдгэрлийн цуглаан



Карабаюу хотын гар алчуурын эдгэрлийн цуглаанд оролцсон үй олон оролцогчид залбирал авсны дараа өвчнөөсөө эдгэрч, индэр дээр гарч ирцгээн гэрчилж байгаа нь. (И Сү жин Пастор)

Манмин Төв Сүмийн пасторуудын холбооны дарга, Есүс Христийн Ариун нэгдсэн сүмийн орлогч дарга И Сү жин пастор нь Өмнөд Америкийн Перу улсад номлогчдын семинар ба гар алчуурын эдгэрлийн цуглааныг удирдан явуулж Бурханд алдрыг өргөв.

Өнгөрөгч дөрөвдүгээр сарын 13-нд, Карабаюу хотод “Эрх мэдэлт гар алчуурын

эдгэрлийн цуглаан” болж өнгөрөв (Үйлс 19:11-12). Тухайн үйл ажиллагааны нээлтэнд орон нутгийн магтаал дууны багийн урлагын тоглолт болсоны дараа Бурханы өгсөн эрх мэдэлт хүч чадлаар бүх хүн төрөлхтөнийг Эзэн рүү хөтөлж буй И Жей руг тэргүүн пасторын ажил үйлсийг агуулсан “Бурханы Хүч Чадал” хэмээх нэртэй DVD-г бичлэг үзүүлэв.

Үүний дараа манай Манмин Төв Сүмийн урлагын багынханы тоглолт эхлэхэд хуран цуглагсад уухайлан алга ташицгааж маш сэтгэл хангалуун байлаа. “Power worship” багынхан Солонгосын үндэсний сэвүүрт бүжиг болон Испани үндэсний бүжгийг бүжиглэн үзүүлэв. Манмин Төв Сүмд үйлчлэгч, солист дуучин Сон Юун хеегийн удирдсан магтаал дууний тоглолт үргэлжлэн явагдаж, оролцогчид талархалын нулимстайгаар, сэтгэл хөдлөм анхилуун үнэрийг Бурхандаа өргөн барив.

И Сү жин пасторт Карабаюу хотын захирагч Рафаел Марселлогоос хүндэтгэлийн дурсгалын пайз гардуулах ёслолын дараа тэрээр “Зөвхөн Есүс яагаад бидний Аврагч вэ?” хэмээх сэдэвт сургаалыг айлдсан ба түүний үргэлжлүүлэн гар алчуураар (Үйлс 19:11-12) хуран цуглагсад зориулан чин сэтгэлээсээ залбирав.

Энэ үед энд тэндгүй тэргэнцэр дээр

сууж байсан олон хүмүүс босон алхаж эхлэв. Баяр баясгалаандаа бялхан дүүрсэн хүмүүс индэр дээр гарч ирэн гэрчлэлүүдээ хуваалцацгаав. Хөхний хавдраас болж нэг талын хөх идээлсэн байсан Пуг Пайн итгэгч нүүрэндээ баяр баясгалантайгаар индэр дээр гарч “Хөндүүрлэх өвчингүй боллоо” гэж гэрчлэн яриу. Үүнээс гадна хараагүй нэгэн нь хараа орж, алхаж чадахгүй доголлон нэгэн нь алхдаг болох зэрэг Карабаюу хот баяр баясгалангаар дүүрэв.

Энэ өдөр сөрөг хүчний намын удирдагч болох Хулиа Роса гишүүн болон бусад олон улс төрчид энэ цуглаанд оролцоогдов. Цуглааны дараа тэд И Сү жин пастор болон дагалдан яваа бие бүрэлдэхүүнийг Перу Улсын Үндэсний парламентийн ордонд хүрэлцэн ирж ерөөлийн залбирал айлдахыг хүсэн урьсан юм.

Дөрөвдүгээр сарын 14-нд И Сү жин пастор нь Перу Манмин цуглаанд болсон Номлогчдын семинар дээр “Зөвхөн Есүс яагаад бидний Аврагч вэ?” болон “Сүмийн сэргэлтийн нууц” хэмээх сургаалиудыг айлдав. “2004 оны Доктор И Жей руг пасторыг урьсан Перугийн нэгдсэн их цуглаан” зохион байгуулах хорооны дарга Фелиппе Үамани пастор болон ойролцоогоор 30 гаруй сүм ба Бразил, Венесуела болон Колумб зэрэг Латин Америкийн 500 гаруй пасторууд энэ

семинарт оролцов.

Семинарын дараа олон номлогчид “Миний итгэлийн амьдралын анхны хайр сэргэлээ”. “Ариун Сүнсээр дүүргэгдэж, гайхамшигт ивээл авлаа”, Миний дотоод эрхтэний өвчтэй байсан гэтэл сургаалиар дамжуулан гэм нүглийнхээ тухай ухаарч гэмшихэд өвдөлт алга боллоо” гэх зэргээр сэтгэл хөдлөн хэлцгээж байлаа. Мөн И Сү жин пастор гар алчуурын (Үйлс 19:11-12) залбирлаар дамжуулан чих, ходоод, нурууны өвчин болон өвдөг зэрэг төрөл бүрийн өвчтэй байсан хүмүүс болон чихрийн шижин, ганцаардах өвчнүүд эдгэрч, хараа сайжирлаа гэж гэрчилцгээж байсан юм.

Дөрөвдүгээр сарын 15-нд, Перу Манмин Сүмийн 6 жилийн ойн баярын үйл ажиллагаа болон Эдгэрэл ивээлийн цуглааны үйл ажиллагаанд 1100-гаад итгэгчид хүрэлцэн ирсэн юм. И Сү жин пастор “Гэрэл дотор үйлдэхэд ерөөл”, “Тэнгэр орон хүчинд автаж байна” хэмээх сургаалиудыг айлдахдаа “гэм нүглийг хаян ариун байдал олвол энэ газарт ч гэсэн ерөөл хүртээд зогсохгүй илүү үзэсгэлэнтэй сайхан тэнгэрийн орон руу орох боломжтой” хэмээн хэлсэн байдаг.

Үүнээс гадна Дөрөвдүгээр сарын 16-нд, номлолын баг нь Перу Манмин сүмийн 500 гаруй итгэгчид оршин суудаг Вентанияа хэмээх газар айлчлан очиж, тэдэнд сүнслэг дүүргэлтээр бэлэг барив.

Түүний дараа, үдээс хойш нь И Сү жин пастор Парламентын гишүүн Хулиа Розагын урилгаар Перугийн Үндэсний Парламентын ордонд зочлов. Тэнд тэрээр олон улс төрчид, парламентын гишүүдтэй уулзан Перу улсын улс төр, эдийн засаг болон нийгмийн асуудлуудын талаар ярилцахаас гадна Манмин Төв сүмийн үйл ажиллагаатай хамтран ажиллах харилцаа холбоог тогтоов. Уулзалтын дараа И Сү жин пастор Перу улсын төлөө ерөөлийн залбирал хийснээр Перуд хийх бүх л үйл ажиллагаа өндөрлөсөн юм.



Перу Манмин сүмийн 6-н жилийн ойн баяр



Перу Манмин сүм дээр зохион байгуулагдсан Номлогчдын Семинар ба магтаалийн цаг



Карабаюу хотод болсон гар алчуурын эдгэрлийн цуглаанд оролцож сэтгэл хөдлөм тоглолт үзүүлж буй “Power worship” багийнхан



Перу улсын Парламентын ордонд зочилж буй номлолын баг



Вентания мужын итгэгчидтэй хамтдаа байгаа И Сү жин пастор



«Загалмайн Үг» цувралаас -(22)

# Мөнх амь (1)

## Итгэдэг гэсэн мөртлөө Аврал хүртэж чадахгүй байх тохиолдол (1)

“Намайг “Эзэн минь”, “Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцгийн хүслийг биелүүлдэг хүн орно” (Матай 7:21)

“Хэрэв хэн нэг нь үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэж байгаа ах дүүгээ харвал, залбиран гуй. Тэгвэл үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэгсдэд амийг Тэр өгнө. Үхэлд хүргэх нүгэл гэж бий. Үүний төлөө залбир гэж би хэлэхгүй. Зөвт бус байдал нь бүгдээрээ нүгэл мөн. Үхэлд хүргэхгүй нүгэл гэж бий” (1 Иохан 5:16-17).

Есүс Христэд итгэдэг болон сүмд явахийн эцсийн зорилго нь бид аврал хүртэж, мөнхийн амьдралд орох нь юм. Гэвч маш олон Христэд итгэгч нар хэдий Бурханы үгээр амьдардаггүй мөртлөө сүмд очиж л байвал аврал хүртэх болно хэмээн бодож байдаг.

Хэрэв бид гэрэл дотор үйлдэн, Бурханы үгийн дагуу амьдрах бус зөвхөн амаараа л итгэдэг гээд Бурхан бидэнд авралыг өгөх боломжгүй бөгөөд үүнийг та мэддэг бол мэдээжийн үйлс дагалддаг жинхэнэ итгэлтэй болох хэрэгтэй билээ. Тэгтэл итгэдэг мөртлөө аврал хүртэж чадахгүй хүмүүс нь чухам ямар хүн бэ? гэдэг талаар тайлбарлая.



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

### 1. Намайг “Эзэн минь”, “Эзэн минь” гэсэн болгон

Матай 7:21-д, Есүс бидэнд, “Намайг “Эзэн минь”, “Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцгийн хүслийг биелүүлдэг хүн орно” хэмээн айлдсан байдаг. Есүсийг “Эзэн минь”, “Эзэн минь” хэмээн дууддаг хүмүүс нь хэдий Есүс Христ бол хүн төрөлхтөний аврагч болохыг мэддэг бөгөөд ингэж дууддаг хүмүүсийн дунд ч тэнгэрийн оронд орох боломжгүй хүн байдаг гэсэн үг билээ.

Үргэлжлүүлэн Матай 7: 22-23-р ишлэлүүдийг үзвэл “Тэр өдөр Надад олон хүн “Эзэн минь”, “Эзэн минь” бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?” гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд, “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ.” Гэсэн байдаг билээ. Хичнээн Эзэнд итгэдэг гээд Эзэний нэрээр ямар нэгэн ажил хийлээ гээд ёс бусыг үйлдэгч хүмүүст Эзэнээс “Би та нарыг огт танихгүй юм байна.” гэж айлдах билээ.

Тиймээс дэлхийн төгсгөл өөрөөр хэлбэл Шүүлтийн өдөр болвол Эзэн ёс бусыг үйлдэж, бүр өөр хүнийг ч хүртэл бүдрүүлдэг атгаг хүмүүсүүдийг ялгаад, мөнхөд асах галтай тамд шидэх болно (Матай 13:40-42).

Энд ёс бусыг үйлдэгч гэдэг нь юуг хэлж байгаа юм бол? 1 Иохан 3:4-д, “Нүгэл үйлддэг хүн бүр ёс бус хэрэг үйлддэг. Нүгэл бол ёс бус хэрэг юм” гэсэн тул үнэний хууль өөрөөр хэлбэл Бурханы үгнээс гажуудах явдал нь ёс бус хэрэг бөгөөд гэм нүгэл билээ. Библи дээр “Бүү хий”, гэснийг хийдэг хүн, “Хая” гэснийг хаяддаггүй хүн, “Сахь” гэдгийг сахидаггүй хүн, зэрэг ийм хүмүүсүүд нь гэм нүгэл үйлддэг хүн билээ.

1 Коринт 6:9-10-д, “Хуурамч шудрага бус хүмүүс Бурханы хаант улсыг хүлээн авахгүй гэдгийг мэдэхгүй гэж үү? Садар самуун үйл үйлдэгчид, хий хоосонг хайгчид, завхай зайдан хүмүүс, хүүхэншүү хүмүүс, ижил хүйтсгэнүүд, хулгайч дээрэмчин хүмүүс, атаархуу хорон санаат хүмүүс, архичин согтуу

хүмүүс, булхай хорон үйлдэгч нар хэзээ ч тэнгэрийн хаант улсад орохгүй билээ.” хэмээн дурдсан байдаг.

Мөн Ром 14:23-д, “Итгэлээр биш алив бүхэн нь нүгэл юм.” хэмээн айлдсан байхад Иаков 4:17-д, “Тийм учир зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ үл үйлддэг хүнд энэ нь нүгэл юм.” гэсэн байдаг билээ. Эцэст нь Бурханы баярлан таалахгүй бүх зүйл нь гэм нүгэл бөгөөд ёс бус зүйл юм. Хичнээн Эзэнд итгэдэг гээд гэм нүглээсээ холдож чадахгүй, ёс бус зүйлийг үйлдсээр л байвал Бурханы улс өөрөөр хэлбэл тэнгэрийн хаанчлалыг өвлөхгүй учраас там руу явахаас өөр аргагүй билээ. (Галат 5:19-21).

Зарим хүмүүс, ийм сургаал сонсоод “Сүмд ирээд удаагүй хүн худал ярьсан ба түүнийхээ төлөө аврал хүртэж чадахгүй юм бол аврал хүртэх хүн хэр олон байгаа вэ?” гэсэн асуулт бий болж болох юм. Эзэнийг хүлээн авлаа гээд шууд бүх гэм нүглээ хаяна гэсэн үг биш юм. Одоохондоо гэм нүглээ бүгдийг хаяж чадаагүй ч гэсэн залбиран, хичээн зүтгэж, өөрчлөгдөж байгаа байдлыг хараад мөн тэр хүний хичээл зүтгэлийг үнэлээд аврал хүртэх итгэлтэй хэмээн Бурхан хүлээн зөвшөөрч өгдөг билээ.

Хэрэв тэр хүн гэм нүглээ хаях гэсэн зүтгэл ч байхгүй урьдын л хэвээр гэм нүглээ үйлдсээр л харин ч эсрэгээр дэлхийн зүйлсэд бага багаар хутгалдвал “Итгэж байна” гэсэн үг нь худал болж хувирдаг юм.

### 2. Үхэл хүргэх гэм нүгэл үйлддэг хүн

Гэм нүглүүдийн дундаас чин сэтгэлээсээ гэмшиж, хаяхын төлөө зүтгэж, уучлагддаг гэм нүгэл байдаг бол тийм биш гэм нүгэл ч бас байдаг билээ.

1 Иохан 5:16-17-д, “Хэрэв хэн нэг нь үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэж байгаа ах дүүгээ харвал, залбиран гуй. Тэгвэл үхэлд хүргэхгүй нүгэл үйлдэгсдэд амийг Тэр өгнө. Үхэлд хүргэх нүгэл гэж бий. Үүний төлөө залбир гэж би хэлэхгүй. Зөвт бус байдал нь бүгдээрээ нүгэл мөн. Үхэлд хүргэхгүй нүгэл гэж бий.” хэмээн дурдсан байдаг.

Үхэлд хүргэхгүй гэм үйлдсэн хүмүүсийн төлөө хичээнгүйлэн санаа тавин, зөвлөж, залбирч өгснөөр гэм нүглээсээ эргэдэг бол, тийм биш үхэлд хүргэх гэм нүгэл ч бас байдаг билээ. Тэгвэл үхэлд хүргэх гэм нүгэл гэж юу вэ?

### 3. Үхэлд Хүргэх Нүгэл: Ариун Сүнснийг доромжлох, саад хийх, эсэргүүцэх

Матай 12: 31-д “ Тиймээс Би та нарт хэлье. Хүмүүсийн аливаа нүгэл хийгээд доромжлол нь уучлагдана. Харин Сүнсний эсрэг доромжлол уучлагдахгүй.” хэмээн айлдсан байдаг ба Лук 12:10-д, “Хүний Хүүгийн эсрэг үг хэлэгч аливаа хүн уучлагдана. Харин Ариун Сүнснийг доромжлогч нэгэн уучлагдахгүй.” гэсэн байдаг билээ.

Ариун Сүнснийг доромжилох гэдэг нь Ариун Сүнсний хүчээр илрэн гарч буй Бурханы хүч нөлөөг муу ёрын сүнсний, сатаны хүч гэж ариун бөгөөд хүчирхэг Ариун Сүнснийг муу ёрын сүнс юм уу сатан гэж доромжлохыг хэлж байгаа билээ.

Ариун Сүнсний үйл ажиллагаанд саад хийх гэдэг нь Ариун Сүнсний хүчээр бий болсон зүйлсийг хараад өөрийн атгаг байдлаасаа болж Бурханы хүч нэлээг үгүйсгэж Бурханы ажил үйлсийг биелүүлэхгүй тулд саад хийх оролдлогыг хэлж байгаа юм. Жишээ нь Ариун Сүнсний хүч нөлөө баялхам дүүрэн сүм цуглаануудыг хараад “Буруу урсгалын сүм, гаж буруу” хэмээн үндэслэл баримтгүйгээр цуурхал, шуугиан тараах зэрэг юм. Энэ нь бүхнийг бүтээгч Бурхантай тэрсэлдэж байгаа хэрэг бөгөөд эсэргүүцэн, Бурхан ажил хэвийн явахад саад болох гэдэг аймшигтай гэм нүгэл юм.

Тиймд бүр цаашлан Ариун сүнсний хүч нөлөөг эсэргүүцэх төлөвлөгөө бий болгох зэрэг эсэргүүцэх элдэв үйлдлүүд улам даамжирвал энэ нь “Ариун Сүнснийг эсэргүүцэх” зүйл болох юм.

Марк 3:20-22-д, Иудейчууд Ариун сүнснийг доромжлон, саад хийж, эсэргүүцдэг хэсэг гардаг билээ. “Есүс гэрт ороход дахиад л бөөн хүн цугларч тэдэнд юм идэх ч завдал өгсөнгүй.

Үүнийг сонсоод хамаатнууд нь Есүсийг авчрахаар явав. Учир нь хүмүүс Түүний тухай -Тэр Өөрийн ухаан мэдрэлээ алджээ гэж ярьж байлаа. Иерусалимаас ирсэн хуулийн багш нар -Тэр Беелзебултэй гээд -Тэр чөтгөрүүдийн захирагчаар чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг гэцгээж байлаа.” хэмээн дурдан бичсэн байдаг.

Есүсийн тухай сураг сонссон хүмүүсийн дунд сайхан сэтгэлтэй хүмүүс нь Түүнд итгэн Бурханд алдрыг өргөж байсан боловч атгаг хүмүүс нь Түүний тухай хорон муу үгийг тарааж байсан юм. Ялангуяа библийг судалдаг хуулийн багш нар фарисейчууд нь энэ тал дээр товчхондоо Эзэнийг үгүйсгэгчдийн тэргүүн эгнээний хүмүүс билээ.

Үргэлжлүүлэн үзэхэд Марк 3:28-29-д “Үнэнээр Би та нарт хэлье. Хүний хөвгүүдийн бүх нүгэл, тэдний ярьсан доромжлол бүхэн уучлагдана. Харин Ариун Сүнснийг доромжлогч хэн ч хэзээ ч уучлагдахгүй бөгөөд мөнх нүглийн гэмтэн болно гэв.” хэмээн айлдсанчлан Ариун Сүнс Бурханы хүчит үйлсийг хараад муу ёрын сүнсний үйлс гэж доромжлон, саад хийдэг, эсэргүүцдэг хүн яаж аврал хүртэх билээ?

Бурханд итгэдэг гэсэн мөртлөө Ариун Сүнсний үйлсийг хараад атаархаж, “Тэмдэг гайхамшиг бол 2000 жилийн өмнө л болсон зүйл. Бурхантай харилцаж гэрчлэл хүлээн авна гэдэг нь маш эрт дээр үед тасарсан” гэлцэж харин ч сатаны хүчээр хийдэг үйлс, гаж буруу урсгал гэдгийг харж болно.

Өчигдөр, өнөөдөр ч мөнхөд хэвээрээ орших Бурхан өнөө үед ч Өөрийг баярлуулдаг, таалалыг олсон хүмүүсээрээр дамжуулан тэмдэг гайхамшгуудыг үйлдсээр л байгаа бөгөөд (Иохан 4:48) үүгээрээ дамжуулан Бурхан одоо Өөрийгөө байгаа гэдгээ харуулсаар л байна. Тиймд энэ мэт Бурханы Ариун Сүнсний хүч нөлөөгөөр бий болсон зүйлсийг эсэргүүцэх нь Бурханыг эсэргүүцэж буй явдал болох бөгөөд уучлагдахгүй гэм нүгэл юм.

Энэ цагт сургаалиар дамжуулан Бурханд итгэдэг гэсэн мөртлөө аврал хүртэж чадахгүй тохиолдол байгааг ухаарч, яасан ч үхлийн зам руу явах явдалгүйгээр шулуун бөгөөд үнэний замаар тэнгэрийн орон хүртэл явж орохыг Эзэн Есүс Христийн нэрээр хүсэн ерөөж байна!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048  
<http://www.manmin.org/english>  
e-mail: [manminministry@hotmail.com](mailto:manminministry@hotmail.com)

Нийтлүүлэгч: Жаерок Лее  
Редактор: Геумсун Вин



# “Би Эдгэршгүй хүнд Өвчнөөс Эзэний ивээлээр эрүүл ЭНХ болсон юм”

И Жом сүг сүмд үйлчлэгч (61 настай Зүүн Гванжу Манмин Сүмийн итгэгч)

Энэ явдал Чeonnam аймаг Тамяанд Мужеон бага сургуульд ажиллаж байхад тохиолдсон юм. Надтай хамт ажилладаг хүмүүс маань миний үйл хөдлөл, үг яриа нэг хэвийн биш байгааг ажиглаж намайг эмнэлэгт очиж үзүүл хэмээн зөвлөв. Үнэндээ би гэр бүлийн тааламжгүй байдлаас болж олон 10 жилийн турш маш хурц сэтгэлийн хямралд амьдарч байсан юм. Би энэ сэтгэлийн хямралаасаа болоод хүмүүстэй харилцахад хүндрэл учирч болон ой санамжын дутагдалтай байв.

Хурц хэлбэрийн тархины хорт хавдраар өвчлөн амьд явах найдвараа алдан амьдарч байхдаа

2010 оны Дөрөвдүгээр сард ажлынхаа хамт олон ба охиныхоо ятгалгаар Чeonnam их сургуулийн харьяа эмнэлгийн мэдрэлийн тасагт үзүүлэхээр очсон юм. Эмч миний биеийн байдал муу байсан учраас ар гэрийнхэн нь дуудах хэрэгтэй гэснээр гэрийнхэнийг минь дуудсан байлаа. Тэр шөнөдөө тархины MRI зураг авсны дараа эмнэлгийн хүлээн авах дээр нэг шөнийг өнгөрөөсөн юм.

Дараагийн өдөр нь би түргэний тэргээр Хуансун Чeonnam их сургуулийн эмнэлгийн хорт халдвар судлалын төв рүү шилжүүлэгдэн олон төрлийн шинжилгээ үргэлжлүүлэн хийлгэв. Тэр үеийг эргэн бодоход хамаг бие хүйт даах шиг болдог юм. Учир нь цаг хугацаа нэлээд алдсан нь мэдээж бөгөөд миний өвчний онош нь хурц хэлбэрийн тархины хорт хавдрын эцсийн үе шатандаа орсон тул маш яаралтай хагалгаанд орох ёстой гэсэн юм. Хагалгааны дараа ч гэсэн миний амьдрах хугацаа зөвхөн тав зургаан сар гэдгийг хэлэв. Гэр бүлийнхэн минь ч энэ байдлыг мэдээж надаас нуусан байсан юм.



Хагалгааны өмнөх тархины MRI зураг: Хурц хэлбэрийн тархины хорт хавдар

Би хагалгааны дараа ч маш хүчтэй эм болон рентген эмчилгээнийг хийлгэж байв. Гэвч “Одоо жоохон гайгүй болж байна” гэсэн хүсэл тэмүүлэлийн оронд бага багаар хоолны дур хүсэл багасаж хүч чадлаа алдсаар л байсан юм. Ой санамж

ч гэсэн урьдын хэвээр орж гарсаар л. Эмнэлэгт 50 орчим хоног хэвтээд гарсан ч гэсэн эцэстээ ажлаасаа гарахаас өөр аргагүй болж, хагалгааны дараах хордлогыг өдөр өдрийг хүндхэн өнгөрөөж байсан юм.

Ухлийн өмнө мөнхийн амьдралыг амссан нь -ыг уншаад миний сэтгэл маш их хөдлөв

2011 оны Нэгдүгээр сарын 2-нд би шинэ оныг угтан Зүүн Гванжу Манмин сүмд анх очсон ба тэр сүмийн итгэгчдийн халуун дотно харьцаа болон хайрыг мэдэрч надад сайхан сэтгэгдэл төрүүлсэн юм. Тэр өдөр би сүмд бүртгүүлэн тэргүүн пастор Доктор И Жей руг пасторын гэрчлэл болох “Ухлийн өмнө мөнхийн амьдралыг амссан” хэмээх номыг бэлгээр хүлээн авав. Доктор И Жей руг пастор нь долоон жилийн турш хүнд өвчний улмаас үхлийн босгон дээр ирсэн ч Бурхантай уулзан бүхий л өвчнөөсөө цэвэрхэн эдгэрсэн тухай түүний гэрчлэлийг уншаад сэтгэл минь ихэд хөдлөж “би ч бас эдгэрэх боломжтой юм байна” гэсэн хүсэл тэмүүлэлтэй хамт амьдарлын тэмүүлэл тэй болов.

Долоо хоног бүр би сургаал сонсон чин сэтгэлээсээ гэмшсэн тул

Би долоо, долоо хоногоор итгэл амьдралаар идэвхтэй зүтгэх тусам Доктор И Жей руг пасторын сургаалиуд нь миний сэтгэлийг маш их хөдөлгөж байсан ба түүний сургаал зөгийн бал мэт амтат дур булаам санагдав. Бүх зүйлд үлгэр жишээ болон үг сургаалиа заадаг учраас амархан ойлгогдож, тэр сургаал болгон миний амьдралын зорилго болсон юм.

Сүмд яваад хоёр долоо хоногийн дараагаас эхлэн манай сүмийн хариуцагч пастор Жон Ёон уг пастор болон ажилтнууд нь манайд 21 хоногийн төлөвлөсөн эргэлт болон гэрийн мөргөл хийж өгсөн юм. Тэр болгонд айлдагдаж буй сургаалиар дамжуулан ухаарсан болгоноо аль болохоор дагаж мөрдөхийг хичээж байв. Юуны өмнө үзэн яддаг, гомдоллож байснаа, хүнтэй муудалцаж байсан зэрэг, зүйлүүд эргэн санагдаж чин сэтгэлээсээ гэмшсэн юм. Тэгж байтал өмнөхөөсөө илүү хүч өгөгдөж, удаан хугацаанд сууж байсан ч яах ч үгүй биетэй болсон байв. Харицагч маань миний итгэл өсч, бие ийн байдал маань ч сайжирсныг хараад Сөүл рүү очин Доктор И Жей руг пасторын залбирлыг авбал ямар вэ? хэмээн зөвлөсөн юм.



Залбирал авсны дараа бие минь эрүүл саруул болон аз жаргалтай болов

2011 оны Хоёрдугаар сард, би догдолсон сэтгэлээр чин сэтгэлээсээ залбирал авахын төлөө бэлтгэсний дараа Доктор И Жей руг пасторын залбирлыг авсан юм. Үүний дараа биеийн байдал маань ч эрс сайжран барайж байсан миний нүүр царай хүртэл цайран, гэрэлтсэн сайхан болов. Өмнө нь би гэрээ ч цэвэрлэж чаддаггүй, мөн ирсэн зочид гийчиддээ сайн үйлчилж чаддаггүй байсан бол одоо би сүмээ хүртэл цэвэрлэдэг болов! Түүгээр ч үл барам Доктор И Жей руг пасторын залбирлын сургаалиудыг сонсон жинхэнэ итгэлийн амьдрал гэдэг бол Эзэний зүрх сэтгэлийг дуурайх явдал юм байна гэдгийг ухааран тасралтгүй залбиран сургаалийн дагуу үйлдэх гэж хичээж байгаа билээ. Зүрх сэтгэл дэх дүүрэн байсан үзэн ядалт ба гомдоллох сэтгэл байхгүй болсон тул сайн унтаж амардаг болж, хоолны дуршил ч гэсэн сайжирсан билээ.

2012 оны Гуравдугаар сард эмнэлэгт очиж шинжилгээ хийлгэхэд намайг эдгэрсэн гэдгийг батлахын тулд эмнэлэг рүү яван MRI зураг авахуулж, шинжилгээ хийлгэсэн юм. Шинжилгээний хариу нь хорт хавдар дахин гарна гэж санаа зоволтгүй бөгөөд цэвэрхэн эдгэрсэн гэдгээ баттай мэдэв. Халлелүяа!

Сүүлийн үед би Эзэний ивээлд талархан 7 хоног бүр “Ман Мин мэдээ” сонинг ойр орчимдоо тарааж байгаа билээ. Ингэж сайн Эзэнтэй олон хүмүүс уулзан, аз жаргалтай амьдраасай гэж хүсэж байна. Бурхандаа бүхий л талархал ба алдрыг өргөхийн сацуу нандин сургаалиар жинхэнэ итгэлийн амьдрал руу удирдаж, залбирал хийж өгсөн Доктор И Жей руг пасторгаа гүн талархалаа илэрхийлье!



## “Доктор И Жей руг пасторын залбирлаар төрөх боломжгүй байсан хүүгээ тэвэрсэн юм”

Сергей Велбовец  
(Ин Виктори медиа группын захирал)

Би Орос хэл дээр мэдээ түгээдэг христчин портал сайт Ин Виктори (www.invictory.org) медиа группын захирал билээ. Ин Виктори нь Доктор И Жей руг пасторын залбирлаар дамжуулан арвин их үр жимс бий болж байгаа билээ.

2011 оны Арванхоёрдугаар сард, миний гэр бүлийнхэн Бурханы хүч чадлыг мэдрэх гайхамшигт зүйл тохиолдсон юм. Миний эхнэр есөн сартай жирэмсэн байсан боловч гэнэтийн тохиолдол түүнд тохиолдов. Хэвлий дэх хүүхэд маань хэд хоногийн турш огт хөдөлж байгаа нь мэдэгдсэнгүй. Бид үүнд их санаа зовж, мөн гайхаж байлаа. Эхлээд бид эмч рүүгээ утасдан ярьсан ба энэ нь таатай бус мэдээ байв. Гэвч үхсэн нэгнийг ч амилуулдаг Бурхандаа найдан, тусалж өгнө гэдэгт итгэн чин сэтгэлээсээ залбирсан юм.

Түүний дараа Солонгосийн Сөүлд байдаг эрх мэдэлт хүчтэй, МанМин төв сүмийн тэргүүн пастор Доктор И Жей руг пасторд залбирлын хүсэлт явуулсан юм. Тэр өдөр 2011 оны Арванхоёрдугаар сарын 16-ны Баасан гариг байв. Гэтэл тэр өдрийн орой залбирал авсны дараа маш гайхамшигтай зүйл тохиолдов. Хэвлий дэх хүүхэд маань хөдөлж эхлэсэн юм. Халлелүяа!

Арванхоёрдугаар сарын 27-нд миний эхнэр хоёр дахь хүүгээ эрүүл саруул төрүүлэв. Хүү маань эрүүл, хэвийн хүүхэд төрлөө гэж байсан юм. Эхнэр маань надад хүүхдээ төрүүлэх үед Бурхан хамт байгааг, мөн амар тайвныг мэдэрч, байсан тухайгаа надад хэлсэн юм.

Мөн бас нэг талархах зүйл нь Доктор И Жей руг пасторыг сургаалиар дамжуулан дэлхийн зүйлстэй хугалдалгүй жинхэнэ сайн мэдээ болох ариун сайн мэдээ сонсох болсон явдал юм. Өнөө үед, олон пасторууд Бурханы таалдаг сургаал айлдахын оронд итгэгчдийн сонсох дуртай зүйлийг л тунхаглаж байдаг. Хэдий тийм ч гэсэн Доктор И Жей руг пасторын сургаалиуд нь Бурханы таалдаггүй, дургүй байдаг гэм нүглүүдийн тухай зааж, зэмлэж, Бурханы сургаалын дагуу амьдардаг жинхэнэ үр хүүхэд нь болох ёстой талаар мэдүүлж өгдөг билээ. Ийм ч учраас Бурхан Доктор И Жей руг пастораар дамжуулан үй олон тэмдэг гайхамшиг, эрх мэдэлт хүчний нөлөөг үзүүлж байгаа гэдэгт итгэдэг юм.

Олон пасторууд Манмин Төв сүмд очиж үзэхийг хүсэцгээдэг билээ. Бурхан амьд гэдгийг баттайгаар үргэлж үзүүлж байдаг Доктор И Жей руг пастортай хамт ажиллана гэдэг нь үнэндээ их нэр төрийн хэрэг билээ.

### Улаанбаатар Манмин Сүм

#### Мөргөлийн цагийн хуваарь

#### залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30			
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00			

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com



# “Эрх мэдэлт хүчтэй гар алчуурын залбирлаар дуу чимээ сонсож эхлэв”

**Жу Сү ёол пастор Тайланд ба Малайзын хэлгүй дүлий итгэгчдийн Манмин сүмийн гар алчуурын эдгэрлийн цуглааныг удирдав.**



Жу Сү ёол пастор нь гар алчуурын (Үйлс 19:11-12) эдгэрлийн залбирал үйлдэхэд сонсголгүй чих сонсдог болж, хараа сайжирч, төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрсэн зэрэг Ариун Сүнсний хүч нөлөө дүүрэн байлаа.

Манай сүмийн хэлгүй дүлий итгэгчдийн багийн хариуцсан пастор Жу Сү ёол пастор нь Тайланд Хат яй Манмин хэлгүй дүлий итгэгчдийн сүмийн 2 жилийн ойн баярт зориулсан үйл ажиллагаанд сургаал айлдаж ийм хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн бий болгосон Тайланд Малайзын хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн нийт 5 салбар сүмд сургаал айлдан гар алчуурын эдгэрлийн цуглааныг зохион явуулав.

2012 тавдугаар сарын 1-нд, эхний цуглаан нь Тайландын Пүкэт хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн Манмин сүмд Жу Сү ёол пастор нь “Зөвхөн Бурхан л амьд оршигч, жинхэнэ Бурхан билээ” (Ром 1:20)-д хэмээх сэдвээр сургаал айлдсаны дараа эрх мэдэлт хүчтэй гар алчуураар (Үйлс 19:11-12) залбирал хийж өгсөн юм.

Энэ үед Кунтон гэх эрэгтэй итгэгч төрөхөөсөө авахуулан саажилттай байсан тэрээр сайн хөдөлдөг болж, үнэрлэх чадвараа алдсан байсан Намкилтай гэх эмэгтэй итгэгч юм үнэрлэх чадвар нь сэргэж, хөлний өвчнөөс болж алхаж чадахгүй байсан Нико гэх эмэгтэй сайн алхдаг болов. Мөн Сайв Тин хэмээх эмэгтэй болон олон хүмүүсийн хараа сайжирч, Каддама Вэчимбут гэх эмэгтэй арьсны үрэвсэлт өвчнөөсөө эдгэрсэн зэрэг төрөл бүрийн сул дорой хэсгүүдээсээ эдгэрэн төгс болж Бурхандаа алдрыг өргөсөн юм.

Тавдугаар сарын 2-нд Сураг Тани Манмин хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн сүмд гар алчуурын эдгэрлийн цуглаанд “Эрх мэдэлт хүч” хэмээх DVD бичлэг үзүүлсэний дараа Жу Сү ёол пастор нь Матай 7:15-17-д дурдсан шиг “Үр жимсгэй итгэгч

болцгооё” сэдэвт сургаал айлдаж, үүний дараа нь өвчтэй хүмүүст зориулан гар алчуураар эдгэрлийн залбирал үйлдэв.

Төрөлхийн сонсголгүй Мантани хэмээх эмэгтэй төрөлхийн “Гар алчуурын залбиралыг авсны дараа Ариун Сүнсний галыг авч, бүх биеэр халуу оргиж байснаа гэнэт дуу чимээ сонсож эхлэв” хэмээн гэрчилсэнд үүнд оролцогчид баяр баясгалантай уур амьсгал дүүрэн байлаа. Үүнээс гадна Чарло Ампол хэмээх эрэгтэйн баруун нүдэнд гэрэл орж ирж байгааг мэдэрсэн ба нарийссан хүүхэн хараань өргөссөж, Жирисуни хэмээх нэгэн эмэгтэй астма болон бамбай булчирхайн өвчнөөсөө эдгэрсэн юм.

Тавдугаар сарын 6-нд, Хат яй Манмин хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн сүм байгуулагдсаны 2 жилийн ойн баяр болон гар алчуурын

эдгэрлийн цуглаан болж өнгөрөв. Үүний дараа Жу Сү ёол пастор Үйлс 4:12 ишлэлийн дагуу “Зөвхөн Есүс яагаад бидний Аврагч болсон тухай” гэсэн сэдэвт сургаал айлдаж түүний дараа эдгэрлийн залбирал үйлдэв. Чансурее Порнуна гэх эмэгтэй итгэгч “Залбирал авсны дараа сонсголгүй чих нь сонсгол орлоо” хэмээн гэрчилж байсан ба Вияанак Коннай “Ариун Сүнсний галыг авсны дараа нүдний хараатай болов”, Сүкун Сүнсүван эмэгтэй “Хөхний хорт хавдартай бөгөөд хөхөнд байсан хатуу булуу нь ариллаа” зэрэг маш олон хүмүүс өвчнөөсөө хэрхэн эдгэрсэн тухай гэрчилж байлаа.

Тавдугаар сарын 7-нд, Тэран Манмин хөгжлийн бэрхшээлтэй итгэгчдийн сүм дээр Жу Сү ёол пастор Еврей 13:8 ишлэлийн дагуу “Өнөөдөр ч гэсэн Бурхан Ариун Сүнсээр

дамжуулан хамт байна” хэмээх сэдэвт сургаал айлдаад өвчтэй хүмүүст зориулан гар алчуураар эдгэрлийн залбирал үйлдэхэд толгой, нүд, мөр, хөл, гар, бэлгэ эрхтэн, цусны өвчин, болон амьсгалын замын өвчнүүдтэй байсан маш олон хүмүүс эдгэрсэн юм.

Тавдугаар сарын 8-нд, тэрбээр Малайз улсын Пенан хотод айлчлан очив. Тавдугаар сарын 9-нд Ний хооронд тэрээр гар алчуурын эдгэрлийн цуглаануудыг удирдан явуулж, итгэгчдийн гэрээр явж танилцсанаар түүний томилолтын ажил өндөрлөсөн юм.

Жу Сү ёол пастор нь (хамгийн зүүн талын) гар алчуурын (Үйлс 19:11-12) эдгэрлийн залбирал үйлдэхэд сонсголгүй чих сонсдог болж, хараа сайжирч, төрөл бүрийн өвчнөөсөө эдгэрсэн зэрэг Ариун Сүнсний хүч нөлөө дүүрэн байлаа.



## “Доктор И Жей руг пасторын сургаал ба эрх мэдэлт хүч манай Мияанмарт агуу ихээр нөлөөлж байна”

Па Хэран Хэмон Пастор  
(Мияанмар хэвлэлийн компанийн захирал)

Би Мианмар улсын хоёр дахь том хот болох Мандалайд байрлах Рай Баптист Сүмийн пастор билээ. Одоо христчин номуудыг Мияанмар хэлээр орчуулан хэвлэн тараах ажил хийдэг билээ.

2006 он миний амьдралд онц чухал үйл явдал болсон жил юм. Энэтхэгээс ирсэн библийн сургуулийн оюутан надад “Ухлийн өмнө мөнхийн амьдралыг амссан нь” хэмээх Доктор И Жей руг пасторын гэрчлэл номыг өгсөн юм.

Тэр номыг уншихад яг л Эзэн

надтай ярьж байгаа мэт мэдрэмж төрж байв. Тэр номыг уншиж байхдаа маш их ивээл ба сэтгэл хөдлөлөөр дүүрч байсан учир Мияанмар хүмүүс ч бас энэ номоор дамжуулан Бурхантай уулзаасай хэмээн ихэд хүсэж байлаа.

Би мөн энэ номыг зохиогчийн талаар нарийн олж мэдэхийг хүсч байсан ба түүний номуудыг нь Мияанмар хэлнээ орчуулан нийтлэхийг чин сэтгэлээсээ хүсэв. Тийнхүү би Урим хэвлэлийн газар луу утасдан Доктор И Жей руг

пасторын номнуудыг Мианмар хэлнээ орчуулах хүсэлтэйгээ мэдэгдэв.

### Миний амьдралд гарсан том эргэлт

2007 оны Гуравдугаар сарын 12-нд би Бурханы ивээлээр Доктор И Жей руг пасторын хайраар орчуулах эрхийг олж авсан юм.

2008 оны Аравдугаар сард би Манмин Төв Сүмд айлчилан очих боломж гарав. Тэр өдөр юу харсанаа би одоо ч болтол мартдаггүй билээ.

Эзэний зүрх сэтгэлийг дуурайх гэж хичээж буй итгэгчдийн итгэл ба Манмин төв сүмд илрэн гарах тэмдэг гайхамшиг болон Бурхан хамт орших Доктор И Жей руг пасторын дүр төрхийг одоо ч тод санаж байдаг.

Далайн шорвог ус амтаг ус болон хувирсан гайхамшигт үйл явдлын талбар Мүан амтаг усны хүрээлэн, төрөл бүрийн арга хэмжээний үеэр бий болох янз бүрийн хэлбэрийн солонго зэрэг тэр чигтэй гайхамшиг гэлтэй. Ням гариг Эзэний өдрийн Хүндэтгэлийн их мөргөл ба Баасан гаригын оройн цуглаан ба Даниелын залбиралын цагаар дамжуулан мэдэрсэн ухаарсан бүх зүйлүүд нь одоог хүртэл миний сүнслэг итгэлийн өсөлтөнд болон миний ажилд асар их дэм болж байгаа билээ.

Энэ хугацаанд гэрчлэлийн ном “Ухлийн өмнө мөнхийн амьдралыг амссан нь”, “Миний Амьдрал Миний Итгэл”, 1, 2-р боть, “Загалмайн Үг” болон “Итгэлийн Хэмжээ” хэмээх номуудыг Мияанмар хэлнээ тус тус орчуулав. Эдгээрээр дамжуулан Доктор И Жей руг пасторын

гайхамшигт номуудаар дамжуулан Бурханы гүн сүнслэг ертөнцийг мэдэх боломжтой нь юутай их ерөөл билээ!

### Эзэний ивээлээр миний өөрчлөгдсөн амьдрал

Мөн ивээлтэй зүйл нь 2010 оны Арваннэгдүгээр сард бий болсон Тайланд болон Мияанмарт болсон эдгэрлийн цуглааны үйл ажиллагаанууд дээр бий болсон тэмдэг гайхамшигууд юм. Үйлсийн 19-р бүлэгт элч Паулын алчуураар дамжуулан гарах тэмдэг шиг Доктор И Жей руг пастораас залбирал авсан гар алчуураар сайн мэдээ тунхаглагч залбирал хийхэд үй олон итгэгчид эдгэрч байгаа байдлыг нүдээр харах боломжтой болсон юм.

Их Эзэнээс Доктор И Жей руг пасторын номуудаар дамжуулан надад маш олон зүйлийг зааж сургасан ба цаашдын ажлын чиглэлийг ч мөн өгсөн билээ. Түүний Их Эзэнийг хайрлах хайр нь бусдаас хамаагүй өөр юм. Би түүний хайр итгэлийг бүх хүмүүстэй хуваалцахыг чин сэтгэлээсээ хүсэж байна.


### Монгол Манмин Төв Сүм

#### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

#### Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



**Хаяг:** Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С  
**Утас:** чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org  
www.manmintv.org